



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

“Мүүн лайт финанс аудит” ХХК-ийг
даатгалын байгууллагад аудит
хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мүүн лайт финанс аудит” ХХК-ийг даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Мүүн лайт финанс аудит” ХХК /А.Саранчимэг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000007